

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛЭЭС АВАХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

## Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

**Санамж:** Энэхүү судалгааны зорилго нь таны хүүхдийн (албан хаагчийн) төгссөн сургуулийн хамтын ажиллагаа болон багш, төгсөгчдийн нэр хүндийн талаар судлахад чиглэнэ. Манай судалгаанд идэвхтэй оролцон их, дээд сургуулийн цаашидын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Жич: Судалгааны мэдээллийн нууцлалыг чанд хадгалан их, дээд сургуулийн сургалт, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ашиглах болно.

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Та асуултыг уншаад тохирох хариултыг сонгоно уу.

### 1. Таны нас

- 25 хүртэл
- 26-35 нас
- 36-45 нас
- 46 ба түүнээс дээш

### 2. Таны хүйс

- Эрэгтэй
- Эмэгтэй
- Бусад

### 3. Таны боловсрол

- Суурь боловсролтой
- Бүрэн дунд боловсролтой
- Дипломын боловсролтой
- Дээд боловсролтой

### 4. Би энэ судалгаанд ..... байр сууринаас оролцож байна.

- Эцэг, эх, асран хамгаалагчийн
- Ажил олгогчийн
- Төгсөгчдийн холбоо
- Мэргэжлийн ТББ

## II. ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН АКАДЕМИК НЭР ХҮНДИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

Та доорх асуулга бүртэй хэр санал нийлж байгаагаа 1-5 хүртэлх оноогоор үнэлж харалдаа мөр бүрд тохирох зөвхөн нэг хариултыг сонгоно уу. Санал огт нийлэхгүй-1, Санал нийлэхгүй-2, Зарим талаар санал нийлнэ-3, Санал нийлнэ-4, Санал бүрэн нийлнэ-5 оноо.

№	Асуулт	1	2	3	4	5
<b>2.1. СУРГУУЛИЙН АКАДЕМИК НЭР ХҮНДИЙН ТАЛААР</b>						
1	Энэ сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, сургалтын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны зорилго, зорилтууд бодитой, хэмжигдэхүйц байдаг					
2	Энэ сургууль үндэсний болон олон улсын стандарт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлдэг					
3	Энэ сургууль нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц шилдэг мэргэжлийн хөтөлбөрүүдээр сургалтын үйл ажиллагаагаа явуулдаг					
4	Сургуулийн удирдлагын баг нь мэдлэг, туршлага, ур чадвар өндөртэй, сургалтын үйл ажиллагаанд шинэлэг арга барилаар ажилладаг					
5	Энэ сургуулийн багшлах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, заах арга зүй нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг					
6	Энэ сургуулийг төгсөгчид хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй, бөгөөд ажлын байраар бүрэн хангагддаг					
7	Энэ сургууль төгсөгчидтэйгөө байнгын эргэх холбоотой ажилладаг					
<b>2.2. СУРГУУЛИЙН СУДАЛГАА, ИННОВАЦИ БОЛОН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР</b>						
8	Сургууль нь боловсролын болон шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлээр сургалт, судалгааны ажил хэрэгжүүлж, шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд хувь нэмрээ оруулдаг					
9	Энэ сургууль нь улс орны хэрэгцээ, тулгамдсан асуудалд нийцсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж, үр дүнг нийтийн хүртээл болгож хэрэглээнд нэвтрүүлдэг					
10	Энэ сургууль нь багш, судлаачдын шинэ мэдлэг бүтээх, ашиглах, дамжуулахад чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжсэн					

	бодлого боловсруулж хэрэгжүүлдэг						
11	Сургууль нь багш, ажилтнуудын бие даасан байдал, академик эрх чөлөөг ханган, шударга ёс, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллахад нь дэмжлэг үзүүлдэг						
12	Энэ сургууль нь эрхэм зорилго, түүнд туссан зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлж санаачилгатай ажилладаг						
13	Сургууль нь: сургуулийнхаа нэр хүндийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлдэг						
14	Гадаад, дотоодын төр болон хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургуультай хамтарсан сургалт, эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээг зохион байгуулдаг						
15	Энэ сургууль нь гадаад, дотоодын их дээд сургуультай багш, оюутан солилцох төсөл, хөтөлбөр зохион байгуулдаг						
16	Сургууль нь үндэсний хэмжээнд боломжит дээд түвшинд эрэмбэлэгдэхийн төлөө тодорхой стратегитай ажиллаж, өрсөлдөх чадвараа хөгжүүлдэг						
<b>2.3. НИЙГМИЙН НЭР ХҮНДИЙН ТАЛААР</b>							
17	Сургууль нь нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг олон нийтэд тодорхой, ойлгомжтой хэлбэрээр шуурхай хүргэдэг						
18	Сургууль нь нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах чиг үүргээ хэрэгжүүлж, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа тогтмол зохион байгуулдаг						
19	Сургууль нь сайн суралцагчдыг урамшуулах, үнэлэх, төрөл бүрийн тэтгэлэг, тэтгэмж, хөнгөлөлт, урамшуулалд хамруулах бодлого, журмыг хэрэгжүүлж ажилладаг						
20	Сургууль нь суралцагчдын ёс суртахуун, бие бялдрын хөгжил болон амжилттай суралцахад нь дэмжлэг үзүүлэх, түүнд тохирсон үйлчилгээг үр дүнтэй үзүүлдэг						
<b>2.4. БАГШИЙН НЭР ХҮНДИЙН ТАЛААР</b>							
21	Энэ сургуулийн багш нарын заах арга зүй, мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага сайн байдаг						
22	Багш, ажилтан, суралцагчид нь үндэсний хэмжээний ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож, ур чадвараа хөгжүүлдэг						
23	Энэ сургуулийн багшлах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, заах арга зүй нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг						
24	Энэ сургуулийн багш нарын судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн нь салбарын хөгжилд хувь нэмэр оруулж, инноваци бүтээдэг						
25	Энэ сургуулийн багш нар нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн ухамсарлаж ёс зүй, хариуцлага өндөртэй байдаг						
<b>2.5. ТӨГСӨГЧДИЙН АМЖИЛТ, АЖЛЫН БАЙРАН ДАХЬ НЭР ХҮНДИЙН ТАЛААР</b>							
26	Энэ сургуулийн төгсөгчид нь мэдлэг, ур чадвараараа салбартаа манлайлдаг						
27	Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагыг салбарын мэргэжилтнүүд өндрөөр үнэлдэг						
28	Төгсөгчид нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн ухамсарлаж ёс зүй, хариуцлага өндөртэй						

Бусад санал, хүсэлт:

БАТАЛГААЖИЛТ /Одоо барьж буй утасны дугаараа оруулна уу./: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_